

Засгийн газраас баталсан “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

2009 оны эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл										
	Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	1999 оны 4-р сарын 21-ний өдрийн 64-р тогтоол										
1.	Хөтөлбөрийн зорилго	Мал сүрэг, аж ахуйн зориулалтаар үржүүлж буй амьтдын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх үндсэн дээр Монгол орон Мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын “А” ангиллын гоц халдварт өвчнүүдээс тайван байгааг хадгалан бататгах, нийгэм, эдийн засагт үлэмж хохирол учруулдаг халдварт, паразиттах өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж мал, амьтны өвчлөл, халдварын хэмжээг аюулгүй түвшинд хүргэх, улмаар Монгол Улсын экспортын боломжийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.										
2.	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатны, хугацаатай нь авч үзэх/	I үе шат 1999-2000 он	а/хилийн мал эмнэлгийн хорио цээрийн найдвартай хамгаалалт бий болгож, мал, амьтны халдварт өвчин, ялангуяа гоц халдварт өвчин улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх;									
		II үе шат 2000-2005 он	б/мал, амьтны халдварт өвчин илэрсэн, дамжин орж ирсэн нөхцөлд тэдгээртэй тэмцэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх бэлэн байдлыг мал эмнэлгийн албаны бүх шатанд бататгах, мал эмнэлгийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлийн хангамж, нөөцийг сайжруулах;									
		III үе шат 2005-2010 он	в/мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, халдвар судлал, ариун цэврийн магадлан шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний мал эмнэлгийн албыг олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх;									
			г/мал эмнэлгийн үйлчилгээг хувийн хэвшлийн нэгжүүдээр гүйцэтгүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, энэ чиглэлийн нэгжүүдийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;									
			д/мал эмнэлгийн улсын хяналтын тогтолцоог боловсронгуй болгон, бүх шатанд бэхжүүлэх, үйл ажиллагааг нь жигдрүүлэх;									
			е/нийгэм, эдийн засгийн хөгжилд ноцтой хор хохирол учруулдаг халдварт өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх.									
3.	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	Хөтөлбөр батлагдах үед 12.0 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцоо хийж байсан.									
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/, үүнээс	49,728,691.70 мянган төгрөг /2008 оны эцэс хүртэл/									
		Тухайн жилд зарцуулсан	6.066.335,0 мянган төгрөг									
4.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн	Биелэлтийн хувь	Нийт	100	90	80	70	50	30	10	0	
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо	5	2		1	2					

үнэлгээ									
5.	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь					
Шалгуур үзүүлэлт тус бүрээр	Энэ үе шатанд бруцеллэз, сүрьеэ, ям, лейкоз, адууны халдварт цус багадах өвчний голомтыг устгах, дээрх өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Бруцеллэзийн тандалт шинжилгээнд 661800 мал хамруулна.	692400 мал бруцеллэз өвчний шинжилгээнд хамруулсан байна.	104,6 %					
		Шинжилгээнд хамрагдсан малыг ээмэгжүүлнэ	70 мянган хээлтүүлэгчийг ээмэглэсэн. (Төвийн бүсийн малыг ээмэгжүүлэх төслийн хүрээнд)	100 %					
		3172,3 мянган охин төлд РЕВ-1 болон 19 дүгээр омгийн вакцинаар урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийнэ	3172,3 охин төл урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан.	100 %					
		Хуц, ухна, бухыг бруцеллэзийн шинжилгээнд бүрэн хамруулна	684549 мал бруцеллэзын шинжилгээнд хамрагдсан бөгөөд энэхүү шинжилгээнд хээлтүүлэгч малыг голлон хамруулсан болно.	100 %					
		Үхрийн сүрьеэ өвчнийг илрүүлэх шинжилгээнд 58000 мянган толгой малыг хамруулна.	54900 үхрийг сүрьеэ өвчний шинжилгээнд хамруулсан.	94,7 %					
		Шинжилгээгээр сүрьеэ өвчний халдвар илэрсэн үхрийг тухай бүрд нь сүргээс ялган тусгаарлаж, мал эмнэлгийн байгууллагын хяналтын дор нядлах замаар эрүүлжүүлнэ.	Шинжилгээгээр халдвар илэрсэн үхрийг нядлах ажил зарим аймагт бүрэн хэрэгжээгүй болно.	80,0 %					
		Бүх адуун сүргийн 3-аас дээш насны адууны 20%-д буюу 81500 адуунд ямлуурын 2 удаагийн сорилыг тавьж шинжлэн ямын голомт, халдварлалтын түвшинг тогтоох.	57000 адуунд халдварт ям өвчний шинжилгээ хийсэн бөгөөд, энэ өвчний халдварлалтыг тогтоосон.	69,9 %					

		Ям өвчин илрүүлэх шинжилгээгээр эерэг гарсан адууг ялгаж мал эмнэлгийн байгууллагын хяналтын дор нядлах замаар адуун сүргийг эрүүлжүүлэх.	Ям өвчний шинжилгээ хийгдсэн бөгөөд халдварлалт илрээгүй болно.	--
		Ям өвчин илрээгүй аймаг, сумын ААН, айл өрхөд гэрчилгээ олгоно.	Хийгдээгүй	0 %
		ТӨ, СЭ, ДА аймаг, УБ хотын арвин ашиг шимт үүлдрийн 230-аас доошгүй үхрийг лейкозын шинжилгээнд хамруулна.	236 дээжинд шинжилгээ хийсэн.	100 %
		Лейкозын шинжилгээгээр эерэг гарсан үхрийг ялган, таних тэмдэг хийж, аажмаар хэрэгцээлнэ.	Лейкоз өвчин оношлогдоогүй	--
		Тугалыг 6 сартайгаас нь эхлэн улирал бүр шинжилж эрүүл гунжийг хээлтүүлэгт оруулан, 7 сарын хээлтэйд нь дахин шинжлэх замаар лейкозоос эрүүлжүүлэх.	Зааврын дагуу хэрэгжиж байгаа	100 %
		СЭ, БУ, ХӨ, ДА, ОР аймгуудын 125400 адуунд ийлдэс судлалын аргаар шинжилгээ хийж АХЦБӨ ¹ -ний халдварлалтын түвшинг тогтоох.	Дээрх таван аймгийн 125800 адуунд АХЦБӨ-ний шинжилгээ хийсэн бөгөөд 965 адуу халдвартай буюу 0,7%-ийн халдварлалттай байна. Бүх эерэг дээжийг УМЭАЦГЛ-иор баталгаажуулсан.	100,3 %
		Шинжилгээгээр эерэг гарсан адууг тухай бүрд ялгаж	Өвчтэй адууг хэрэгцээлэх үед олгох нөхөн төлбөрийг 2009	100 %

¹ Адууны халдварт цус багасах өвчин

		<p>мал эмнэлгийн хяналтын дор хэрэгцээлүүлэх замаар адуун сүргийг эрүүлжүүлэх.</p>	<p>онд “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”-д заасны дагуу бүрэн олгосон тул төлөвлөсөн арга хэмжээг иж бүрэн цогцолбороор хэрэгжүүлсэн байна.</p>	
		<p>Шинжилгээгээр АХЦБӨ илрээгүй аймаг, сумдын ААН, айл өрхийн адуун сүрэг АХЦБӨ-өөс эрүүлжсэнийг баталгаажуулан гэрчилгээ олгоно.</p>	<p>Хийгдээгүй</p>	<p>0 %</p>
		<p>АХЦБӨ-нөөр өвчилсөн адууны судалгаа, мониторинг гаргах.</p>	<p>Эпизоотологийн судалгаа хийгдсэн.</p>	<p>100 %</p>
	<p>Монгол Улсад тохиолдож байгаа бактер, мөөгөнцөр, риккетси, микоплазм, вирусын гаралтай өвчнүүд, цусны паразитгах болон цус сорогч үе хөлтнөөр дамжин халдварладаг өвчнийг бүрэн оношлон бүртгэж, эдгээр өвчнийг хянах, тэдгээртэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний стратегийг боловсруулна.</p>	<p>- Мал, амьтны халдварт өвчин, ялангуяа гоц халдварт өвчин улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. - Мал эмнэлгийн албаны бүх шатанд мал эмнэлгийн үйлчилгээний багаж хэрэгсэл, эм бэлдмэлийн хангамж, нөөцийг сайжруулна. - Мал, амьтны халдварт өвчин илэрсэн тохиолдолд тэдгээр өвчнүүдтэй тэмцэх арга хэмжээний стратегийг боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ. - Монгол Улсад тохиолдож байгаа халдварт, паразитгах</p>	<p>▪ Хөрш зэргэлдээ Хятад улсын тэжээвэр шувуунд H5N1-ийн дэгдэлт их гарсан бөгөөд манай улс зохих арга хэмжээ авч, хэрэгжүүлсний үр дүнд тэжээвэр шувуунд халдвар гараагүй. ▪ Шүлхий өвчний вакцинжуулалтын ажил зүүн аймгуудад хийгдэж байгаа ба энэ өвчнөөс эрүүлжсэнийг баталгаажуулах ажил үнэлгээний шатандаа хэрэгжиж байгаа. ▪ Үхрийн цээж өвчнөөс эрүүлжсэнийг баталгаажуулах ажил хийгдэж материалыг ДМАЭМБ-д илгээгээсэн. ▪ ХХААХҮЯ-ын ТНБД-ын тушаалаар томилогдсон тендерийн үнэлгээний хороо Мал эмнэлгийн арга хэмжээнд хэрэглэгдэх эм, биобэлдмэлийн, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, оношлуур,</p>	<p>80,0 %</p>

		<p>өвчнийг бүрэн оношлон бүртгэж, эдгээр өвчнийг хянах, тэдгээртэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний стратегийг боловсруулна.</p>	<p>ариутгалын бэлдмэл худалдан авах тендерийн сонгон шалгаруулалтыг хугацаанд зохион байгуулж, хүргэх ажлыг хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Сүүлийн жилүүдэд манай орны мал, амьтанд шинээр оношлогдож байгаа аденоматоз, маеди висна, хламидоз, хөх хэлтэх, гахайн амьсгал үржлийн замын хам шинж, актинобациллёз, гахайн сонгомол мялзан, ауескийн өвчин, гахайн салстын өвчин, хачигт энцефалит, баруун Нилийн халуурал, үхрийн папилломатоз, сенсциал вирусийн халдвар, адууны вирусийн артерит, сохор догол, шөвөг яр, туулайн вируст цусан халдвар зэрэг өвчний тандах шинжилгээ хийсэн. ▪ Гоц халдварт, халдварт өвчнийг оношлох аймаг, нийслэл, улсын мал эмнэлгийн лабораторийн хүчин чадал дээшилсэн, мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадавх сайжирсан. 	
	<p>Мал эмнэлгийн лаборатори, хил, гүний хяналтын салбарт ажиллаж байгаа эмч нарыг нарийн мэргэжлийн дамжаагаар сургаж, мэргэшүүлсэн байна.</p>	<p>Орон нутгийн МЭҮН-ийн малын эмч нар, төвийн болон орон нутгийн лабораторийн эмч нарыг дотоод, гадаадын сургалт, семинарт хамруулна.</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Баруун, төв, говийн бүсийн малын эмч нарын чуулга уулзалт зохиогдсон. ▪ Малын эмч нарын итгэмжлэл олгох сургалтыг ХХААХҮЯ, МҮМЭХ, МЭБС, УМЭАЦТЛ, МЭҮГ хамтран зохион байгуулсан. ▪ МҮМЭХ, гадаадын мэргэжилтэн бусад байгууллагатай хамтран малын эмч, 	<p>100 %</p>

			<p>мэргэжилтний мэргэжил, ажлын дадлага туршлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн 13 удаагийн сургалт зохион байгуулж 1541 хүн оролцсон.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Мөн Европын холбоо, Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлагийн шугамаар хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд сургалт, семинар зохион байгуулсан.
6.	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц	<ul style="list-style-type: none"> ▪ Энэ төсөлтэй уялдсан “Үхрийн арьсны гууртай тэмцэх төсөл”, “Малын зарим архаг халдварт өвчинтэй тэмцэх” төсөл хэрэгжиж дууссан, “Үхэр хонь, ямааны бруцеллёзтой тэмцэх төсөл” хэрэгжиж байгаа. ▪ Орон нутгийн мал эмнэлгийн лабораторийн бэлэн байдлыг хангах зорилгоор мэргэжилтнүүдийн сургалтыг зохион байгуулж, 22 аймаг, нийслэлийн МЭА болон лабораторийг тоног төхөөрөмж, оношлогооны багаж, эм оношлуураар хангасан. 	
7.	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/	<ul style="list-style-type: none"> ▪ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрыг байгуулснаар халдварын голомтыг устгах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг МЭ-ийн бүх шатанд цогцолбор байдлаар хэрэгжүүлэх нөхцөл бүрджээ. ▪ Зарим халдварт өвчнөөс эрүүлжсэнийг баталгаажуулах бэлтгэл хангагдсан. ▪ МЭ-ийн салбарт ажиллагсдын мэдлэг, чадавхийг дээшлүүлэх чиглэлээр гадаад улс орнуудын хамтын ажиллагаа сайжирч, дотоодын үйл ажиллагаа тогтворжсон. ▪ Зарим халдварт, архаг халдварт өвчний өвчлөл, халдварлалтын хэмжээ орон нутаг, бүс нутгийн хэмжээнд буурсан дүн гарсан. 	
8.	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал	<ul style="list-style-type: none"> ▪ Мал эмнэлгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, бүх шатанд бэхжүүлэх зорилт хүрээнд хэрэгжүүлсэн ажил үр дүн муутай дутагдал ихтэй байна. ▪ МЭ-ийн байгууллагын бүтэц, тогтолцоо нь улсын, аймаг, нийслэлийн гэсэн хэлбэрээр үндэсний боон дунд шатны бүтэцтэй байгаа бөгөөд сумын түвшинд зөвхөн хувийн мал эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа нь олон тооны сөрөг үр дагаварыг үүсгэж байна. ▪ Бруцеллёз, сүрьеэ зэрэг өвчнөөс тайван аж ахуй, сум, аймагт эрүүлжсэнийг баталгаажуулах гэрчилгээ олгох ажил зохион байгуулалтын дутагдалтай холбоотойгоор хэрэгжиж чадахгүй байна. ▪ Бруцеллёз өвчний шинжилгээгээр эерэг гарсан малыг ээмэгжүүлж, буцаан ялгах таних ажил хангалттай сайн зохион байгуулагдаж чадахгүй байна. 	
9.	Эдгээрээс гарах арга зам	<ul style="list-style-type: none"> ▪ Мал эмнэлгийн үйлчилгээ, вакцинжуулалтын чанарт хянал тавьдаг тогтолцоог боловсронгуй болгох. 	

		<ul style="list-style-type: none"> ▪ Монгол мал хөтөлбөрийн хүрээнд сум бүрт төрийн мал эмнэлгийн нэгж байгуулан үйл ажиллагааг нь тогтворжуулах. ▪ Халдварт өвчнөөс эрүүл өрх, АА, сум, аймгийн сертификат олгож, урамшуулдаг тогтолцоо бий болгох. ▪ Аймаг, сумын түвшинд малыг бүртгэлжүүлэх, ялган таних тогтолцоог бий болгох
10	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаарх үнэлгээ	СЯ, БСПУЯ, БХЯ, ЭМЯ, УМХЕГ зэрэг газрууд тодорхой үүрэгтэйгээр оролцдог. Мал эмнэлэг, эрүүл мэндийн салбар, мэргэжлийн хяналтын байгууллагын хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй, үйл ажиллагаа давхардах, дунд нь орхигдох зэрэг зөрчлүүд тохиодож байгаагийн улмаас хөтөлбөрийн зарим үйл ажиллагаа хэрэгжихэд бэрхшээл учирч байна.
11	Хөтөлбөрийн талаарх яамны санал /өөрчлөн сайжруулах, бодлогод үзүүлж буй хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх гэх мэт/	Хөтөлбөр 2010 онд дуусна. Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн бусад төслүүдийн үр дүн сайн хангалттай гэсэн дүнтэй дүгнэгдсэн.
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцооны талаарх санал /дэд хөтөлбөртэй байх, тухайн аймагт заавал хэрэгжүүлэх шаардлагатай эсэх гэх мэт/	Орон нутгийн байгууллага, мэргэжилтнүүдээс үнэлж, дүгнэх, төв байгууллагад мэдээлэх, ажлыг оновчтой зохион байгуулах талаар хангалтгүй ажиллажээ. Мөн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зарим үйл ажиллагааны санхүүжилтийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөсөн боловч тэднээс үзүүлэх дэмжлэг хангалтгүй байгаагаас зарим үйл ажиллагаа хангалттай хэрэгжиж чадахгүй байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА